



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

“Чингэлтэйн боловсрол-2028”
арга хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, удирдлагын менежментийг сайжруулах, олон улсын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, сургалтын чанар, гүйцэтгэлийн зөрүүтэй байдлыг арилгах зорилго бүхий “Чингэлтэйн боловсрол-2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны
өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт

“ЧИНГЭЛТЭЙН БОЛОВСРОЛ - 2028” АРГА ХЭМЖЭЭ

Нэг.Нийтлэг үндэслэл

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн хэмжээнд боловсролын салбарын нэгдсэн бодлогыг тодорхойлж, дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын дагуу “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Боловсролын ерөнхий хууль, Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (2021-2030), “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэл, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан “Чингэлтэйн боловсрол-2028” арга хэмжээг боловсрууллаа.

Монгол Улсын Засгийн газар, Боловсролын яам, нийслэл, дүүргийн төр захиргааны байгууллагын зүгээс боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд суралцагчийн хөгжил, хамгаалал, багшийн хөгжил, байгууллага, удирдлагын менежментийг дээшлүүлэх, суралцах, хөгжих тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж, шинээр сургууль, цэцэрлэг байгуулах зэрэг материаллаг асуудлыг бодлогын түвшинд дэмжин ажиллаж байгаа бөгөөд сургуулийн удирдлагын менежментийг сайжруулах, байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээг ахиулах, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний зөрүүтэй байдлыг багасгах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжиж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлж ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад бүх шатанд анхааран ажиллаж байна.

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн Ерөнхий боловсролын 26 сургууль болон Насан туршийн суралцахуйн төвд нийт 890 бүлгийн 29724 суралцагч суралцаж байгаагаас бага боловсролд 13015, суурь боловсролд 10616, бүрэн дунд боловсролд 6093 суралцагч хамрагдан суралцаж байна. Төрийн болон төрийн бус өмчийн 48 цэцэрлэгийн 341 бүлэгт 9059 хүүхэд, багачуудыг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, сургалт хүмүүжлийн ажлыг зохион байгуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт дунджаар 33.4 буюу нэг багшид ногдох хүүхдийн тоо 24 байгаа ч сургууль бүр дээр харилцан адилгүй байгаа ба тухайлбал, Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль 41.7, Ерөнхий боловсролын 23 дугаар сургууль 54.7 байгаа нь боловсролын тэгш байдлын асуудал зөрчигдөж

байгааг харуулж байна. Сургуулийн өмнөх боловсролын бүлэг дүүргэлт 26.5 ба бүлгийн багш, туслах багшид ногдох хүүхдийн тоо 13.2 байгаа нь өмнөх хичээлийн жилийн статистик тоотой харьцуулахад сургуулийн өмнөх боловсролын бүлэг дүүргэлт 5.6 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Тэгш хамран сургалтыг дэмжих, ялгаатай хэрэгцээт хүүхдийг боловсролд тэгш хамруулах ажлыг нэмэгдүүлснээр ерөнхий боловсролын сургуульд 149, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 64 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч хамрагдан суралцаж байна.

Чингэлтэй дүүргийн сургууль төгсөгчдийн элсэлтийн шалгалтын дундаж бусад дүүрэг, аймгуудтай харьцуулахад жил бүр тодорхой хувиар ахиж байгаа хэдий ч үр дүнд хүрэхгүй байгаа нь нийт сурагчдын сурлагын чанар, сургалтын тэгш хүртээмжтэй байдал, багшлах боловсон хүчний хүрэлцээ, бага дунд ахлах ангийн залгамж холбооны уялдаа зэрэг олон асуудлаас шалтгаалж байгаа бөгөөд Чингэлтэй дүүргийн 2024 оны төгсөгчдийн элсэлтийн шалгалтын дундаж оноо 496 байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 22.4 оноогоор буурсан үзүүлэлттэй байгаа нь уг арга хэмжээг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх гол үндэслэл болсон юм.

Багш нарын мэргэжлийн мэдлэг чадвар, заах арга зүй, гадаад хэлний мэдлэг, мэдээлэл харилцааны дэвшилтэт технологитой ажиллах, сурагчдыг оношлох, үнэлэх, үр дүнд баримжаалан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, түүнд дүн шинжилгээ хийх зэрэг чадварууд харилцан адилгүй байсаар байна. Өөрөөр хэлбэл багш бүр орчин үеийн хүүхдүүдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн, сурагчдын сурч боловсрох, хөгжих үйлийн ахиц, үр дүнд баримжаалсан сургалтын үйл ажиллагааг төлөвлөж сурах нь сурагчдын мэдлэг чадварын ахицад шууд нөлөөлдөг. Иймээс хүний хөгжлийг хөтлөгч багшийн хөгжлийн асуудалд илүү анхаарч, бодлого төлөвлөлтөөр чиглүүлж, шат ахиулан хөгжүүлэх, боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, удирдлагын багийн менежментийг сайжруулах, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дунджийг нэмэгдүүлэх, дээд доод гүйцэтгэлийн зөрүүг багасгах зэрэг хэрэгцээ шаардлага байгаа юм.

Мөн дүүргийн Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 89.8 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх оноос 0.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд 1836 багш, ажилчид ажиллаж байгаагаас 1241 нь үндсэн багш, харин сургуулийн өмнөх боловсролын салбарт нийт 1422 багш, ажилтан ажиллаж байгаагаас 379 бүлгийн багш, туслах багш 362 ажиллаж байна.

Чингэлтэй дүүргийн боловсролын салбарын статистик мэдээлэл, ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн элсэлтийн шалгалтын мэдээлэл, багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг үндэслэн Боловсролын салбарын гол оролцогч талууд болох суралцагчийн хөгжил, хамгаалал, багшийн хөгжил, нийгмийн дэмжлэг, байгууллагын хөгжил, удирдлагын манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор "Чингэлтэйн боловсрол-2028" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр.Арга хэмжээний зорилго

Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, удирдлагын менежментийг сайжруулж, олон улсын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх, өргөжүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлэн, сургалтын чанар, гүйцэтгэлийн зөрүүтэй байдлыг арилгахад арга хэмжээний зорилго оршино.

Гурав.Арга хэмжээний зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

Зорилт 1.Суралцагчийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх замаар сургалтын үйл ажиллагааны чанарыг ахиулна.

Зорилт 1-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.1.Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, төлөвшлийг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн уралдаан тэмцээн, үйл ажиллагааг зохион байгуулна.

1.2.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нэмэгдүүлэх зорилгоор судлагдахуун тус бүрийн дүүргийн шатны олимпиадыг зохион байгуулна.

1.3.Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийн дунд олон улсын хөтөлбөрийн сургалтыг нэмэгдүүлэх, эзэмшсэн байдлын түвшнийг тогтоон, урамшуулах арга хэмжээг зохион байгуулна.

1.4.Монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, зөв дадал хэвшилтэй монгол хүнийг төлөвшүүлэх зорилгоор “Би Монгол хүүхэд” үйл ажиллагааг жил бүр өргөжүүлэн зохион байгуулна.

1.5.Хүүхэд хамгаалал, хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, цахим гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын хамтын ажиллагааг сайжруулж, сургалт, үйл ажиллагаа зохион байгуулна.

1.6.Хүүхдийн өөрийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, удирдах шатны хүүхдүүдийг хөгжүүлэх, бие биеэсээ харилцан суралцах замаар бусад гишүүдэд нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.

1.7.Элсэлтийн шалгалтаар 800 оноо авсан сурагч, бэлтгэсэн багш нарыг урамшуулах “Элсэлтийн шалгалт 800” уралдааныг жил бүр зохион байгуулж, төгсөгчдийн элсэлтийн шалгалтын дунджийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн:

-Хүүхдийн авьяас, мэдлэг, чадвар төлөвшил, хандлагад ахиц гарсан байна.

-Сурагчдын шинжлэх ухааны мэдлэг, чадвар сайжирч, дараагийн шатны олимпиадад бэлтгэгдсэн байна.

-Сургалтын орчин сайжирч сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж нэмэгдэнэ.

-Сурагчид эх орныхоо түүх соёл, уламжлалт зан, заншлаар бахархаж, хүнлэг, эх оронч иргэн болж төлөвшинө.

-Эцэг эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч бусад талуудын үүрэг оролцоо нэмэгдэнэ.

Зорилт 2.Багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн олон төрөлт үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 2-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

2.1.Багш, удирдах ажилтны мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний түвшнийг ойртуулах, дунджийг ахиулах арга хэмжээг зохион байгуулж, урамшуулна.

2.2.Боловсролын байгууллагын удирдлага, багш нарын дунд эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан, заах арга зүй, ур чадварын уралдаан, биеийн тамир, спортыг хөгжүүлэх уралдаант арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.

2.3.Сургалтын байгууллагад суралцаж буй тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийг чадавхжуулах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хууль тогтоомжид заасан нэмэгдэл урамшуулал олгох ажлуудыг зохион байгуулна.

2.4.Хамтран ажилладаг байгууллагын дэмжлэгээр дотоод гадаадын сургалт үйл ажиллагаанд багш, ажилтнуудыг хамруулах, багш, сурагч солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.5.Багшийн гаргасан амжилтыг үнэлж, шударгаар өрсөлдөх боломж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн баталгаагаар хангах ажлуудыг шат дараатай зохион байгуулна.

Хүрэх үр дүн:

-Багшийн арга зүй, ур чадварт ахиц гарч, урамшуулал авах багш, байгууллагын тоо нэмэгдэнэ.

-Боловсролын салбарт чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ.

-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тэгш хамрагдалт нэмэгдэнэ, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ахиц гарч, урамшуулал авах багшийн тоо нэмэгдэнэ.

-Багшийн мэдлэг, ур чадвар нэмэгдэн бусад орны соёлд суралцаж цаашид суралцах хүсэл сонирхол нэмэгдэнэ.

-Амжилт бүтээлээ шударгаар үнэлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлснээр чадварлаг багш нарын нийгмийн баталгаа хангагдах нөхцөл бүрдэнэ.

Зорилт 3.Удирдлагын менежмент, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулахад чиглэсэн олон төрөлт үйл ажиллагааг зохион байгуулна.

Зорилт 3-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

3.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх, тайлан гаргахад дэмжлэг үзүүлэх сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулна.

3.2.Сургууль, цэцэрлэгийн дэргэдэх ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг чанаржуулж багш, удирдах ажилтан, эцэг эхэд чиглэсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна.

3.3.Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, найрсаг хандлагыг бий болгох чиглэлээр “Чингэлтэй боловсрол-Эерэг хандлага” уралдаант аяны арга хэмжээ зохион байгуулна.

3.4.Шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн барилгын бүтээн байгуулалтын ажлын явцад хяналт тавих, их болон урсгал засвар шаардлагатай сургууль, цэцэрлэгийн судалгааг гаргаж холбогдох газруудад хүргэн, засварын ажилд хяналт тавин хамтарч ажиллана.

3.5.Боловсролын байгууллага бүрийг “Хүүхдийн аюулгүй бүс” уриа дор үе тэнгийн дээрэлхэлгүй, замын болон орчны аюулгүй бүс болгох ажлуудыг зохион байгуулна.

Хүрэх үр дүн:

-Стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл, үр дүн сайжирна.

-Сургууль, цэцэрлэгийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа тогтворжино.

-Байгууллагын дотоод соёлд ахиц гарч, багш ажилтан, асран хамгаалагчийн уялдаа холбоо сайжирна. Сурагчдын хүмүүжил ёс суртахуунд эергээр нөлөөлнө.

-Сургалтын тав тухтай орчин бий болсноор сурагч, багш, ажилчдын, сурлагын ахиц болон ажлын амжилтад эергээр нөлөөлнө.

-Сургууль, цэцэрлэгийн орчин хүүхдэд ээлтэй, аюулгүй тайван, тав тухтай орчин болно.

Дөрөв.Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчмууд

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг боловсролын байгууллага, хүүхэд, багш, удирдлагын хөгжлийн бодит хэрэгцээнд тулгуурлан тодорхойлж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ доорх зарчмыг баримтална. Үүнд:

- ✓ Үйл ажиллагаа нээлттэй, хэрэгжихүйц, тогтвортой байх
- ✓ Багш, суралцагч, удирдлага болон боловсролын байгууллагуудад хөгжих тэгш боломж олгох
- ✓ Багш, удирдлагын мэргэжлийн хөгжлийг дэмжих үйлийг сургууль, цэцэрлэгт суурилан зохион байгуулах
- ✓ Багшийн мэргэжлийн хөгжлийн сургалтууд тэдний хэрэгцээ, шаардлагыг хангах
- ✓ Төр, төрийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хариуцлагад тулгуурлах;

Тав.Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1.“Чингэлтэйн боловсрол-2028” арга хэмжээг 2025-2028 он хүртэл нийт 4 жилийн хугацаанд 3 зорилт, 17 үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ

5.2.Арга хэмжээний санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

5.2.1.Улс, нийслэлийн төсөв

5.2.2.Орон нутгийн төсөв

5.2.3.Олон улсын болон төрийн бус байгууллагын дэмжлэг

5.2.4.Бусад эх үүсвэр

Зургаа.Арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт

6.1.Арга хэмжээний хэрэгжилтийг дүүргийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн хэмжээнд удирдлага, төлөвлөлт, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд Чингэлтэй дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгүүдийн удирдлага, багш, суралцагч, ажилтан албан хаагчид, эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулж, идэвх оролцоог хангаж ажиллана.

6.3. Арга хэмжээний хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн цахим сүлжээгээр тогтмол сурталчлан ажиллах ба боловсролын салбарын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах чиглэлд анхаарч ажиллана.

Долоо. Арга хэмжээний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ:

Арга хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 192 дугаар тогтоолоор батлагдсан “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн үр дүнг мөн уялдуулан тооцно. Хөтөлбөр хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийснээр цаашид сайжруулан, анхаарч ажиллах чиглэлийг тодотгон дүүргийн боловсролын байгууллагуудад танилцуулан жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган ажиллана.

Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг дараах аргачлалаар дүгнэнэ.

- ✓ “Үр дүнтэй”- зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь (90%-100%)
- ✓ “Тодорхой үр дүнд хүрсэн” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (60%-89% хүртэл)
- ✓ “Эрчимжүүлэх шаардлагатай”- зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь (31%-59% хүртэл)
- ✓ “Үр дүн багатай” - зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0 – (0%-30% хүртэл)

Хяналт-шинжилгээ үнэлгээг Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн манлайлал дор ажлын хэсэг гүйцэтгэнэ.

Хяналт - шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа, авах арга хэмжээ:

-Явцын дотоод үнэлгээ /жилд 2 удаа/ - хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол удирдлагаар хангахад дэмжлэг үзүүлэн, тулгарсан бэрхшээлийг тодорхойлж сайжруулалт хийх, ахицыг үнэлэх

-Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ /2026 онд/ - Хүрсэн үр дүн, бэрхшээлийг тооцож сайжруулах гарцыг тодорхойлж, шаардлагатай бол зорилт, үйл ажиллагаанд тодотгол хийх

-Хөтөлбөрийн эцсийн үнэлгээ /2028 онд/ - үйл ажиллагааны тоон чанарт бус, бодит үр дүн, зэрэг нөлөөнд суурилсан үнэлгээ хийх, цаашдын бодлого төлөвлөлтөд оруулах саналыг боловсруулах

Хөтөлбөрийн суурь түвшин:

Тус хөтөлбөрийн суурь түвшинд Чингэлтэй дүүргийн боловсролын салбарын өмнөх оны статистик мэдээ болон сургууль, цэцэрлэгийн байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлангийн биелэлтийн үнэлгээг оруулан тооцно. Мөн доорх чиглэлд сургууль, цэцэрлэгийн тоон болон чанарын үнэлгээг оруулна. Үүнд:

- ✓ Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын "PISA 2025" үнэлгээ
- ✓ Хүний нөөцийн судалгаа /боловсрол, мэргэжлийн зэрэг/
- ✓ Мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, хүчин чадлын судалгаа
- ✓ Сурлагын дүнгийн дундаж
- ✓ ЭШ-ын дүнгийн дундаж
- ✓ Багш нарын монгол бичгийн чадварын үнэлгээ
- ✓ Багш нарын мэдээлэл технологийн хэрэглээ, үйлдлийн программ эзэмшсэн байдал
- ✓ Багш нарын тухайн жил сургалтад хамрагдсан тоон мэдээлэл
- ✓ Багш нарын эрүүл мэндийн байдал
- ✓ Багш нарын ажлын байран дахь сэтгэл ханамжийн судалгааны үр дүн
- ✓ Эцэг, эхийн сургуулийн үйл ажиллагаа, багшийн заах арга барил, чадвар, ёс зүй, хүүхдийн хөгжил, сурлагын ахиц зэрэгт өгсөн сэтгэл ханамжийн судалгаа

Хөтөлбөрийн хяналт-шалгалт, үнэлгээг хийхдээ ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хөтөлбөр хэрэгжилтийн өөрийн үнэлгээ, багш нарын сэтгэл ханамжийн судалгаа, Боловсролын удирдах байгууллагаас хийсэн хяналт, шалгалтын үнэлгээ зэргийг оруулж тооцно.

Шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин			
				2025 он	2026 он	2027 он	2028 он
Зорилт 1: Суралцагчийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх замаар сургалтын үйл ажиллагааны чанарыг ахиулна.							
1.	Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, төлөвшлийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан	тоо	5	6	7	7	8

	уралдаан тэмцээн, үйл ажиллагааны тоо						
2.	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нэмэгдүүлэх зорилгоор судлагдахуун тус бүрийн дүүргийн шатны олимпиадыг зохион байгуулсан хувь	хувь	90	92	95	97	100
3.	Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийн дунд олон улсын хөтөлбөрийн сургалтыг нэмэгдүүлэх, эзэмшсэн байдлын түвшнийг тогтоон, урамшуулах арга хэмжээг зохион байгуулсан тоо	тоо	38	52	73	94	114
4.	Монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, зөв дадал хэвшилтэй монгол хүнийг төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулсан "Би Монгол хүүхэд" үйл ажиллагаанд оролцогчдын хувь	хувь	80	85	90	95	100
5.	Хүүхэд хамгаалал, хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, цахим гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэхэд хүрээнд эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан сургалт, үйл ажиллагааны тоо	тоо	5	6	7	7	8
6.	Хүүхдийн өөрийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, удирдах шатны хүүхдүүдийг хөгжүүлэх, бие биеэсээ харилцан суралцах замаар бусад гишүүдэд нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан тоо	тоо	2	3	4	4	5
7.	Төгсөгчдийн элсэлтийн шалгалтын дундаж оноо	Дундаж оноо	496	498	500	502	504
Зорилт 2.Багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн олон төрөлт үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.							
1.	Багш, удирдах ажилтны мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний түвшнийг ойртуулах, дунджийг ахиулах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	тоо	2	3	4	5	5

2.	Боловсролын байгууллагын удирдлага, багш нарын дунд эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан, заах арга зүй, ур чадварын уралдаан, биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	тоо	4	5	6	7	8
3.	Сургалтын байгууллагад суралцаж буй тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийг чадавхжуулах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хууль тогтоомжид заасан нэмэгдэл урамшуулал олгох чиглэлээр зохион байгуулсан ажлын тоо	тоо	2	2	4	6	8
4.	Хамтран ажилладаг байгууллагын дэмжлэгээр дотоод гадаадын сургалт үйл ажиллагаанд багш, ажилтнуудыг хамруулах, багш, сурагч солилцооны хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан ажлын тоо	тоо	4	5	5	6	6
5.	Багшийн гаргасан ажилтныг үнэлж, шударгаар өрсөлдөх боломж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн баталгаагаар хангагдсан багшийн тоо	тоо	10	10	15	18	20
Зорилт 3.Удирдлагын менежмент, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулахад чиглэсэн олон төрөлт үйл ажиллагааг зохион байгуулна.							
1.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх, тайлан гаргахад дэмжлэг үзүүлэх сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтын тоо	тоо	0	2	3	3	4
2.	Сургууль, цэцэрлэгийн дэргэдэх ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг чанаржуулж багш, удирдах ажилтан, эцэг эхэд чиглүүлэн зохион байгуулсан сургалт, үйл ажиллагааны тоо	тоо	4	4	5	5	6

3.	Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, найрсаг хандлагыг бий болгох чиглэлээр "Чингэлтэй боловсрол-Эерэг хандлага" уралдаант аяны гүйцэтгэлийн хувь	хувь	0	70	80	90	100
4.	Шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн барилгын бүтээн байгуулалтын ажлын явцад хяналт тавих, их болон урсгал засвар шаардлагатай сургууль, цэцэрлэгийн судалгааг гаргаж холбогдох газруудад хүргэн, засварын ажилд хяналт тавин хамтарч ажилласан гүйцэтгэлийн хувь	хувь	100	100	100	100	100
5.	Боловсролын байгууллага бүрийг "Хүүхдийн аюулгүй бүс" уриа дор үе тэнгийн дээрэлхэлгүй, замын болон орчны аюулгүй бүс болгох чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	тоо	0	5	6	7	8